

**БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Байгууллагын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээг хийж, үр дүнг үнэлэв.

Үнэлгээний хүрээнд байгууллагын 2023 оны эхний хагас жилийн Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн болно.

Нэг. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар

Тус байгууллага нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хүрээнд 2023 оны эхний хагас жилд Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тусгагдсан 3 арга хэмжээний 4 зүйл, заалтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.1. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харуулбал:

№	Зүйл, заалт	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Дундаж хувь	Дундаж оноо
1	2	3	4	5
1 (27)	1.Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах хавсралтад дурдсан улсын иргэдийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсүгэй. 2.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай.	Визийн шаардлагаас чөлөөлөх тухай, 2023-01-04, Дугаар 2023_1	100	5.0
Хэсгийн дундаж: 100 хувь				

Хэрэгжилт 1: Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах 34 улсын иргэнийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоолоор визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээс хавсралтад дурдсан улсыг хасаж, шийдвэрийг үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

1.2. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харуулбал:

№	Зүйл, заалт	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Дундаж хувь	Дундаж оноо
1	2	3	4	5
2 (66)	ХХХҮҮ.Бүгд Найрамдах Хятад Ард Улс 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс хилийн боомтоо шат дараатайгаар нээхтэй холбогдуулан хэрэгжиж эхлэх дэглэмийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хилийн Гашуунсухайт боомтыг хэвийн үйл ажиллагаанд шилжих хүртэлх хугацаанд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Х.Нямбаатар, Хилийн боомтын захиргаа (Ш.Лхачинжав) нарт даалгав: 1.хилийн Гашуунсухайт боомт дахь тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах түр журмыг баталж, мөрдүүлэх; 2.хилийн Гашуунсухайт боомтын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа, орон нутаг дахь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах Шуурхай штабын бүрэлдэхүүнийг томилж, үйл ажиллагааг удирдлагаар хангах.	2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2022-12-28 Дугаар 2022_63	100	5.0
3 (67)	II..Тогтоол батлагдсантай холбогдуулан “Монгол Улсын визийг цахимаар авах улсын жагсаалт”-д өөрчлөлт оруулах, гадаадын бусад улсыг нэмж хамруулах асуудлыг холбогдох байгууллагын саналыг харгалзан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт даалгав.	2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр 01 дүгээр тэмдэглэл 2023-01-04 Дугаар 2023_1	100	5.0
4 (68)	II.3.Тогтоол батлагдсантай холбогдуулан гадаадын иргэдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар) нарт даалгав.		100	5.0
Хэсгийн дундаж: 100 хувь				

Хэрэгжилт 2: Тус боомтын дахин төлөвлөлтийн асуудлаар Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод байрлах “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал”-ын зураг төсөлд тусгах саналыг 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/267 дугаар албан бичгээр “Смарт эко транс” ХХК-д хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга нар 05 дугаар сарын 26-ны өдөр Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод ажиллаж, боомтын зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах үүрэг өгөв. Хилийн Гашуунсухайт боомтын зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх бэлтгэл ажлын хүрээнд үйл ажиллагааны болон “ISM” системийн

бэлэн байдлыг хангасан ба тайлант хугацаанд зорчигчийн хөдөлгөөн нээгдээгүй болно.

Хэрэгжилт 3: Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор зарим улсын иргэнийг визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn) дэх бүртгэлээс хавсралтад дурдсан 34 улсыг хасаж, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/09, А/53 дугаар хамтарсан тушаалаар 98 улсыг цахим виз олгох улсын жагсаалтад нэмснийг уг системд бүрэн нэвтрүүлж, нийт 99 улсын иргэнд цахим визийг олгож байна.

Хэрэгжилт 4: Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоол болон Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/09, А/53 дугаар хамтарсан тушаалыг мөрдөж эхэлснээс хойш тайлант хугацаанд “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээр нийт 40 улсын 5233 иргэнд цахим виз олгожээ.

Хоёр. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн талаар

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд 2022 онд 1 арга хэмжээний 1 зорилт, арга хэмжээг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ” зорилтын хүрээнд хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харуулбал:

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Дундаж хувь	Дундаж оноо
1	2	3	4	5	6
1 (2.7.3)	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	30	1.5

Хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 483 дугаар тогтоолоор “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”, мөн 484 дүгээр тогтоолоор “Монгол Улсын виз олгох журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулснаар гадаадын иргэний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох эрх зүй, суурь нөхцөлийг илүү сайжруулан ажиллаж байна.

“Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем” (ISM) дэх мэдээллийн санг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд хөрвүүлэх программыг хөгжүүлж, 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар үйл ажиллагааны бэлэн байдлыг хангалаа.

Визийн зөвшөөрлийн хүсэлт илгээх болон хүлээн авах төлбөрийн модулийг хэсэгчлэн гүйцэтгэж, хүсэлтийг хуваарилах, шийдвэрлэх, ажилтны хандах эрх үүсгэх тохиргоог системд оруулан төлөвлөгөөний дагуу программ хангамжийг шат дараатай хөгжүүлж байна.

Гурав. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаар

Тус байгууллагаас хэрэгжүүлж байгаа 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувийг хүснэгтээр харуулбал:

№	ХБТББ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Дундаж хувь	Дундаж оноо
1	2	3	4	5	6
1	4.3.9. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно	2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	30	1.5
2	4.2.1. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно	1.Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.	Төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.	100	5.0
3	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	3.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	100	5.0
Хэсгийн дундаж: 77 хувь					

Хэрэгжилт 1: “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем” (ISM) дэх мэдээллийн санг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд хөрвүүлэх программыг хөгжүүлж, 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар үйл ажиллагааны бэлэн байдлыг хангалаа.

Визийн зөвшөөрлийн хүсэлт илгээх болон хүлээн авах төлбөрийн модулийг хэсэгчлэн гүйцэтгэв. Түүнчлэн визийн зөвшөөрлийн хүсэлтийг хуваарилах, шийдвэрлэх, ажилтны хандах эрх үүсгэх тохиргоог системд оруулсан.

Хэрэгжилт 2: “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус баталж, байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудасны нүүр хэсэгт авлигыг мэдээлэх 976-110 тусгай дугаарын мэдээллийг байршуулсан.

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авах Авлигатай тэмцэх газрын 976-110, өргөдөл гомдол хүлээн авах байгууллагын 70133480, дотоод хяналт шалгалтын 70133464 дугаарын утсыг нийтэлсэн сурталчилгааны хуудас (постер)-ыг англи, монгол хэл дээр төв байгууллага, харьяа нэгжүүдийн үйлчилгээний заал, хилийн боомтуудын байранд тус тус байршуулж, байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түгээлээ.

Төрийн албан хаагчийг авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын даргын 2021 оны Б/139 дугаар тушаалаар орон нутаг дахь газрын захиргааны ахлах мэргэжилтнүүдийг салбар ЭБАТ-аар томилон ажиллуулж байна.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” 46 дугаар мэдэгдлийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайланг байгууллагын даргын 05 дугаар сарын 23-ны өдрийн 01/885 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст хүргүүлэв.

Хэрэгжилт 3: Байгууллагын даргын 2021 оны А/62 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021-2024 оны хөтөлбөр”-ийг шинэчлэн баталснаар жил бүр сургалтын болон нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны сургалтын төлөвлөгөө”-ний дагуу хагас жилийн байдлаар төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллын чиглэлээр “Албан хаагчдын имиж бүрдүүлэлт, биеэ авч явах байдал”, “Үйлчилгээний соёл, харилцаа хандлага, бухимдалтай үйлчлүүлэгчтэй харилцах үеийн арга техник”, “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн зохицуулалт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй ба авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх”, “Стресс менежмент”, “Удирдах албан тушаалтны харилцаа хандлага”, “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь”, “Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, тогтолцоо бүрдүүлэх” сэдэвт сургалтуудыг бусад байгууллагатай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 893 албан хаагч хамруулан ажиллалаа.

Санал: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаснаар Засгийн газрын 2021 оны 261 дүгээр тогтоолоор тус үйл ажиллагааны хөтөлбөрийн “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог

боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд “Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна” арга хэмжээг холбогдох байгууллагуудад тусгайлан хариуцуулсан тул манай байгууллагын хяналтаас хасуулах саналтай байна.

Дүгнэлт, зөвлөмж:

Байгууллагын бодлогын баримт бичгийн 2023 оны эхний хагас жилийн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт 100 хувь буюу 5.0 оноотой, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт 77 хувь буюу 3.9 оноотой байна.

Ерөнхий үнэлгээ 88.5 хувь буюу 4.4 оноотой байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 хувиар өсчээ. Хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт		Үнэлгээ				Харьцуулалт /хувиар/
		2022 оны эхний хагас жил		2023 оны эхний хагас жил		
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт	99	4.95	100	5.0	+1
	2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	70	3.5	77	3.9	+7
Ерөнхий үнэлгээ		84.5	4.2	88.5	4.4	+4

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт 30 хувь буюу 1.5 оноотой байна.

Зөвлөмж:

- Байгууллагын бодлогын баримт бичгийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд үнэлгээг хийсэн тул Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан журамд заасны дагуу хэрэгжилтийг Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;
- Үнэлгээний хүрээнд байгууллагын 2023 оны эхний хагас жилийн Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй дүгнэгдсэн тул арга хэмжээний үр дүнг бууруулахгүйгээр жилийн эцэст зорилт, арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж ажиллах;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-д тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл

бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт"-ийн арга хэмжээний хэрэгжилтийг ахиулах, өөрөөр хэлбэл “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагаа жилийн эцэст хэвийн явагддаг болсон байх зорилт тавьсан тул уг арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТЭС